



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

дод. 3. 10. од № ХТ/д103  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Ерөнхий сайдын мэдээллийн тухай

“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт хийх болсныг үүгээр уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,  
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201  
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,  
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,  
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2023.10.02 № ХЯТ/2102  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Мэдээлэл хүргүүлэх тухай

Улсын Их Хурлын чуулганы 2023 оны 10 дугаар сарын 06-ны өдрийн нэгдсэн хуралдаанд хийх "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаарх Ерөнхий сайдын мэдээллийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт <sup>13</sup> хуудастай.

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН



## **“ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО”-Д ТУСГАГДСАН ЗАМ, ТЭЭВРИЙН САЛБАРЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЛААР УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ НЭГДСЭН ХУРАЛДААНД ХИЙХ МЭДЭЭЛЭЛ**

Зам, тээврийн салбар 2023 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар бүх төрлийн тээврээр нийт 72.6 сая тн ачаа, 105.4 сая зорчигч тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс ачаа тээвэр 1.5 дахин буюу 51.4 хувиар, зорчигч тээвэр 1.1 хувиар тус тус өссөн байна.

Зам, тээврийн салбар 2023 онд 400.25 км хатуу хучилттай авто зам, 928.83 у/м төмөрбетон гүүрийг улсын байнгын ашиглалтад оруулж, бүх төрлийн тээврээр 69 сая тн ачаа тээвэрлэхээр төлөвлөөд байна.

**“Шинэ сэргэлтийн бодлого”-д тусгагдсан зам, тээврийн салбарын төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн талаар**

### **Төмөр замын төслүүд:**

*1. Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр замын төсөл*

**Төслийн захиалагч:** “Монголын төмөр зам” ТӨХК

**Төсөл гүйцэтгэгч:** “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК

**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** “Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам” ХХК

**Төслийн ТЭЗҮ зураг төслийн өртөг:** 51.3 тэрбум төгрөг

**Төслийн нийт өртөг:** 4.3 тэрбум ам.доллар

**Төслийн санхүүжилтийн хэлбэр:** Концесс

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2026 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор “I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц” гэж үзэж, нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах зорилгоор суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан I, II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийн “барих-ашиглах-шилжүүлэх” концессыг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

Мөн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолд Баруун болон Зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлэх, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын сүлжээг байгуулна гэж тус тус заасан.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор концессын “зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх” төрлөөр Арцсуурь-Нарийнсухайт-



Шивээхүрэн төмөр замын төслийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас сонгон, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн оролцоотой төслийн тусгай зориулалтын компани байгуулж хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.

#### **Төслийн ач холбогдол:**

- Баруун бүсийн эдийн засаг, тээвэр логистик болон транзит тээврийн хөгжил шинэ түвшинд гарна;
- Бараа бүтээгдэхүүн, ажиллах хүч, капиталын чөлөөт урсгал бий болж, олон мянган тогтвортой ажлын байр шинээр бий болно;
- Бүс нутгийн аялал жуулчлалын кластер хөгжиж, олон улсын аялал жуулчлалын сүлжээнд нэгдэн, төвлөрлийг сааруулахад бодит хувь нэмэр оруулна;
- ОХУ-аас бараа, бүтээгдэхүүнийг Хятадад, Хятадын ачаа барааг Европ гэсэн 2 чиглэлд дамжин өнгөрүүлэх ачаа болон зорчигч тээвэрлэлт бий болгож, хуурай замын томоохон боомт хотыг хөгжүүлэх боломж нөхцөл бүрдэнэ;
- Баруун бүсийн уул уурхайн баялаг эдийн засгийн эргэлтэд орно.

**Төслийн ажлын явц:** 2021 онд ЗТХЯ-ны захиалгаар "Урбан девелопмент консалтинг групп" ХХК нь Баруун чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн урьдчилсан судалгааг хийж гүйцэтгэсэн бөгөөд нийт 1255 км урттай, жилд 30 сая тн ачаа тээх хүчин чадалтай байна.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын суурь бүтцийг барих төсөлд хөрөнгө оруулах дотоод, гадаадын аж ахуй нэгжийг сонгох ажлыг 2022.05.17-ны өдөр зохион байгуулж, урьдчилсан сонголтын шалгуур үзүүлэлтийн баримт бичгийг нийт 46 компанид хүргүүлэн, саналыг 2022.06.08-ны өдөр хүлээн авсан.

"Монголын төмөр зам" ТӨХК болон "Ийст коридор рэйлрөүд" ХХК нар "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр зам" ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн гэрээг 2023.06.09-ний өдөр гарын үсэг зурж баталгаажуулсан бөгөөд тусгай зориулалтын компанийн Улсын бүртгэлийн гэрчилгээг 2023.07.03-ны өдөр авсан.

Төслийн төмөр замын суурь бүтэц барих техник-эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгаврыг ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга 2023.01.24-ний өдөр баталсан.

Засгийн газрын 2023.08.30-ны өдрийн 35 дугаар тэмдэглэлээр тус чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанитай концессын шууд гэрээ байгуулах талаар дүгнэлт гаргахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, дүгнэлтийг үндэслэн хэлэлцээ хийж, зохих журмын дагуу гэрээ байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан.

Улмаар Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын тушаалаар концессын шууд гэрээ байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

*2. Шивээхүрэн-Сэхэ хилийн боомтын нарийн царигийн 7.1 км төмөр замын төсөл*



**Төслийн захиалагч:** “Шивээхүрэн төмөр зам” ХХК  
**Төсөл хэрэгжүүлэгч:** “Нарийнсухайтын төмөр зам” ХХК  
**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** “Хятадын зураг төслийн групп” ХХК  
**Төслийн ТЭЗҮ зураг төслийн өртөг:** 4.5 тэрбум төгрөг  
**Төслийн нийт өртөг:** 207.7 тэрбум төгрөг  
**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023 он

**Төслийн ач холбогдол:** Шивээхүрэн хилийн боомтын нарийн царигийн төмөр зам нь Монгол, Хятад 2 улсын хил дамнасан төмөр зам болох, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр замын хэсэг болох, мөн нүүрсний экспортыг нэмэгдүүлэх шинэ гарц болох зэрэг утгаараа стратегийн хувьд онцгой ач холбогдолтой.

Шивээхүрэн хилийн боомтын ачаа нэвтрүүлэх хүчин чадал өнөөгийн байдлаар 10 сая тн байгааг 2 дахин нэмэгдүүлж, 20 сая тн-д хүргэх боломж бүрдэнэ.

**Төслийн ажлын явц:** “Нарийнсухайтын төмөр зам” ХХК болон “Монголын төмөр зам” ТӨХК хамтарч “Шивээхүрэн төмөр зам” ХХК-ийг 2023 оны 03 дугаар сард байгуулсан.

Тус чиглэлийн төмөр замын нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг 2023.03.14-ний өдөр батлуулж, Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан технологийн зөвлөлийн 2023.05.22-ны өдрийн хурлаар Шивээхүрэн-Сэхэ хил дамнасан төмөр замын ТЭЗҮ-ийг хэлэлцэн дэмжсэн.

Засгийн газрын 2023.05.17-ны өдрийн 186 дугаар тогтоолоор Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрөл болон барилгын ажлын зөвшөөрлийг “Нарийнсухайтын төмөр зам” ХХК-д тус тус олгосон.

Улмаар Шивээхүрэн-Сэхэ боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг эхлүүлэх нээлтийн үйл ажиллагааг 2023.05.27-ны өдөр зохион байгуулсан.

Шивээхүрэн хилийн боомтын төмөр замын төслийн иж бүрэн нарийвчилсан зураг төслийг боловсруулж, Хятадын талаас ирүүлсэн бөгөөд Хятад хэлнээс Монгол хэлэнд хөрвүүлэн ажиллаж байна. Мөн Шивээхүрэн боомтын төмөр замын БОННУ-г батлуулах ажил явагдаж байна.

Төслийн барилгын ажил эхэлсэн бөгөөд 2023.09.22-ны өдрийн байдлаар газар шорооны ажил 61 хувьтай, эрчим хүчний ажил 24.92 хувьтай, өртөө зөрлөгийн барилга угсралтын ажил 7.67 хувьтай, ус зайлуулах байгууламжийн ажил 5.84 хувьтай байна.

### *3. Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426 км төмөр замын төсөл*

**Төслийн захиалагч:** “Монголын төмөр зам” ТӨХК  
**Төсөл хэрэгжүүлэгч:** “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК  
**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** “Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр зам” ХХК  
**Төслийн нийт өртөг:** 2.15 тэрбум ам.доллар  
**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2025 он



**Төслийн эрх зүйн үндэслэл:** "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоол, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 3-т тус тус тусгагдсан.

Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг, 2013 оны 28 дугаар тогтоолоор төмөр замын суурь бүтцийн "барих-ашиглах-шилжүүлэх" концессыг "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус олгосон.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолоор концессын "зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр Чойбалсан-Хөөт-Бичигт төмөр замын төслийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас сонгон, "Монголын төмөр зам" ТӨХК-ийн оролцоотой төслийн тусгай зориулалтын компани байгуулж хамтран хэрэгжүүлэхээр тусгасан.

**Төслийн ач холбогдол:**

- Зүүн бүсийн төмөр зам баригдсанаар олон ордуудын нөөцийн ангилал нь геологийн нөөцөөс эдийн засгийн үр ашигтай нөөцийн ангилал руу шилжиж, бүс нутгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулах боломжтой;
- Монгол Улсаар дамжин өнгөрөх экспортын хэмжээ нэмэгдэж, Европ-Азийг холбосон транзит тээврийн шинэ гарц бий болж, эдийн засагт онцгой ач холбогдол үзүүлнэ;
- БНХАУ болон ОХУ-ын газар нутгаар дамжин далайн чанад дахь зах зээлд хүрч, экспортын шинэ гарцуудыг бий болгон, эцсийн хэрэглэгчид шууд хүргэнэ;
- Төмөр зам баригдсанаар зөвхөн уул уурхайн салбарт бус, хүнс, мал аж ахуйн салбар, арьс ширний үйлдвэрлэл, тэдгээрийн логистикт чухал нөлөөг үзүүлнэ;
- Төмөр замын бүтээн байгуулалтыг дагасан томоохон суурьшлын төвүүд бий болохоос гадна олон ажлын байр шинээр бий болно.

**Төслийн ажлын явц:** Зүүн босоо буюу Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын урьдчилсан ТЭЗҮ-ийг 2017 онд "Хятадын төмөр замын инженер консалтинг групп" ХХК хийсний дагуу тус төмөр замын төсөл нь жилд 25 сая тн ачаа тээх хүчин чадалтай, 2.15 тэрбум ам.долларын төсөвт өртөгтэй байна.

2014 онд "Ниппон Коей" компани техникийн зөвлөх үйлчилгээ, "МакКинсей компани" "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого"-ын I, II үе шатны төмөр замын техник эдийн засгийн урьдчилсан судалгааг тус тус хийсэн.

Засгийн газрын 2022 оны 116 дугаар тогтоолын дагуу "Монголын төмөр зам" ТӨХК-аас зарласан Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426 км төмөр замын сонгон шалгаруулалтад "Ийст корридор рэйлрөүд" ХХК оролцож, 2023.02.03-ны өдөр шалгарсан.

"Монголын төмөр зам" ТӨХК болон "Ийст Корридор Рэйлрөүд" ХХК-ууд хувьцаа эзэмшигчдийн гэрээг эцэслэн тохирч, 2023.06.15-ны өдөр гэрээнд талууд гарын үсэг зурсан ба "Чойбалсан-Хөөт-Бичигт" ХХК байгуулагдаж, улсын бүртгэлд 2023.07.03-ны өдөр бүртгүүлсэн.

"Хөөт-Бичигт" чиглэлийн 234 км төмөр замын ТЭЗҮ-ийг БНХАУ-ын China Railway Design Corporation Ltd (CRDC)-тэй гэрээ байгуулан гүйцэтгүүлж байна. Мөн



БНХАУ-ын "Хятадын Хөх мөрөн нефть химийн групп" ("China Yangtze River Petrochemical Group Limited") компанитай нэг консерциум болон уг төслийг хамтран хэрэгжүүлэхээр тохирч, 2023.06.28-ний өдөр БНХАУ-ын Бээжин хотноо хөрөнгө оруулалтын хэлэлцээр байгуулсан.

Төслийн 1 дүгээр шатны буюу Бичигт-Зүүн хатавч чиглэлийн хил орчмын төмөр замын ТЭЗҮ болон зураг төслийг "Монголын төмөр зам" ТӨХК хариуцан гүйцэтгэж байна.

"Ийст корридор рэйлрөүд" ХХК нь Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замын хээрийн судалгааны ажлууд болон ТЭЗҮ, зураг төслийг гүйцэтгэж, төслийн хөрөнгө оруулалтыг шийдвэрлэн, бүтээн байгуулахаар тохиролцоод байна.

Мөн геологи, геодези, археологи, палентологи, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, судалгаануудыг гүйцэтгэж байна.

Засгийн газрын 2023.08.30-ны өдрийн 35 дугаар тэмдэглэлээр тус чиглэлийн төмөр замын төслийг хэрэгжүүлэх тусгай зориулалтын компанитай концессын шууд гэрээ байгуулах талаар дүгнэлт гаргахыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт, дүгнэлтийг үндэслэн хэлэлцээ хийж, зохих журмын дагуу гэрээ байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдад даалгасан.

Улмаар Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын тушаалаар концессын шууд гэрээ байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

*4. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан холболтын 18.9 км төмөр замын төсөл*

**Төслийн захиалагч:** "Тавантолгой төмөр зам" ХХК

**Төсөл хэрэгжүүлэгч:** Тодорхойгүй

**Төслийн ТЭЗҮ, зураг төсөл:** "Хятадын зураг төслийн групп" ХХК

**Төслийн ТЭЗҮ, зураг төслийн өртөг:** 16.3 тэрбум төгрөг

**Төслийн нийт өртөг:** Тодорхойгүй

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2025 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** 2022 онд БНХАУ-ын Төрийн зөвлөлийн гишүүн бөгөөд Гадаад хэргийн сайдын айлчлалын үеэр "Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон БНХАУ-ын Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо хоорондын Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын холболтын тухай харилцан ойлголцлын санамж бичиг" байгуулсан.

"Тавантолгой төмөр зам" ХХК, "Эрдэнэс Тавантолгой" ХК болон БНХАУ-ын "Чайна Энержи" ХХК-аас "Монгол, Хятадын Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам болон нүүрс худалдах, худалдан авах талаар хамтран ажиллах ерөнхий хэлэлцээр"-ийг 2022.08.08-ны өдөр Талууд цахимаар гарын үсэг зурж баталгаажуулсан.

**Төслийн ач холбогдол:** Тавантолгой-Зүүнбаян, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замыг бүрэн хүчин чадлаар ажиллуулж, жилд 30 сая тн ачаа тээвэрлэх боломж бүрдэнэ.



**Төслийн ажлын явц:** ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны тушаалаар "Гашуунсухайт-Ганцмод хилийн боомтыг төмөр замаар холбох ажлын техник эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлын даалгавар"-г батлуулсан.

Хил холболтын төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах Зөвлөх үйлчилгээний тендерийг 2023.02.27-ны өдөр зарлаж, 2023.03.13-ны өдөр нээн, 8 аж ахуй нэгж материал ирүүлсэн.

Тендерийн хуулийн 14-16 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаагүй тул дахин сонгон шалгаруулалтыг 2023.03.30-ны өдөр нээсэн. Нийт 10 оролцогч саналаа ирүүлснээс 8 оролцогчийг хураангуй жагсаалтад оруулж, хураангуй жагсаалтын саналын урилгыг 2023.03.31-ний өдөр нийтэлсэн.

Улмаар хураангуй жагсаалтын саналын урилгыг 2023.05.01-ний өдөр нээж, санал ирүүлсэн 5 байгууллагын саналыг хянан, 2 байгууллагын техникийн санал шаардлага хангасан тухай мэдэгдлийг хүргүүлсэн. Шаардлага хангасан 2 байгууллагын техникийн саналыг үнэлж, 1 байгууллага босго оноо давсан ба тус байгууллагын Санхүүгийн саналыг 2023.05.12-ны өдөр нээсэн.

2023.05.19-ний өдөр гэрээ байгуулах мэдэгдлээ хүргүүлж, "Тавантолгой төмөр зам" ХХК болон "Хятадын зураг төслийн групп" ХХК нар Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний гэрээг 2023.05.26-ны өдөр байгуулсан.

Засгийн газрын 2023 оны 310 дугаар тогтоолоор "Тавантолгой төмөр зам" ХХК-д Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг олгоод байна.

2023.08.21-ний өдөр Зам, тээврийн салбарын шинжлэх ухаан технологийн Зөвлөлийн хурлаар ТЭЗҮ-ийг хэлэлцүүлэн санал өгч, дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. Зөвлөлийн саналын дагуу ТЭЗҮ-ийн төслийг засаж ажиллаж байна.

#### **5. Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл**

**Төсөл хэрэгжүүлэгч:** "Монголиан транслайн" ХХК

**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** "Монголиан транслайн" ХХК

**Төслийн нийт өртөг:** 381.1 сая ам.доллар

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2024 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолд тусгагдаж, Засгийн газрын 2022 оны 28 дугаар тогтоолоор "Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын төсөл"-ийг концессын "Зураг төсөл боловсруулах-барих-ашиглах-шилжүүлэх" төрлөөр шууд гэрээ байгуулах, Засгийн газрын 2022 оны 104 дүгээр тогтоолоор гэрээ байгуулах эрх олгосон.

#### **Төслийн ач холбогдол:**

- Уул уурхайн бүтээгдэхүүний экспортын хэмжээг жилд 20-25 сая тн-оор нэмэгдүүлэх Монгол-Хятадын хилийн төмөр замын хоёр дахь шинэ гарцтай болж, бусад төмөр замуудын вагон эргэлтийн хугацаа хурдсаж, экспорт, импортын ачааны бөөгнөрлийн хэмжээ багасна;



- “УБТЗ” ХНН-ийн гол замын ачаа Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар тээвэрлэгдсэнээр жилд 6-8 сая тн транзит ачаа нэмэх боломж “УБТЗ” ХНН-т бүрдэнэ;
- Сайншандаас Бугат хотын чиглэлд төмөр замын тээврийн зай 890 км-ээс 648 км болж 242 км-ээр богиносон, энэ чиглэлд вагон урсгал 17.2 хувиар нэмэгдэнэ. Тус чиглэлд Монголын нутгаар тээвэрлэх зай 240 км-ээс 386 км болж 146 км-ээр нэмэгдэх бол Хятадын нутгаар тээвэрлэх зай 650 км-ээс 262 км болж 388 км-ээр багасна. Ингэснээр Монголын нутгаар тээвэрлэх төмөр замын тээврийн нэмүү өртөг тн тутамд 10 ам.доллар-р нэмэгдэнэ;
- Тавантолгой-Цагаан цав чиглэлд төмөр замын ашиглалт сайжирч, Тавантолгой-Ханги чиглэлд нүүрсний экспорт жилд 13-15 сая тн-оор нэмэгдэнэ;
- Таван толгой-Ханги-Мандалын чиглэлд төмөр замаар нүүрс тээвэрлэснээр тээврийн өртгийг тн тутамд 19 ам.доллар болгон бууруулж, Тавантолгойн нүүрсний өөрийн үнэ цэнэ тн тутамд 40 ам.доллар-р нэмэгдэх боломжтой;
- Төмөр замын тээврийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой 1200 орчим хүний тогтвортой ажлын байр бий болж, төмөр замын тээврийн салбарт шууд бусаар 2500-3000 хүн тогтмол орлоготой болно;
- Төмөр зам баригдсанаар малын бэлчээр сүйтгэх, тоосжилт, дуу шуугиан, хөрс болон агаарын бохирдол багасаж, бүс нутгийн авто тээврийн осол зөрчил буурна.

**Төслийн ажлын явц:** Зам, тээврийн хөгжлийн сайд 2022.11.23-ны өдөр БНХАУ-ын Тээврийн сайд Ли Шяопэнтэй цахим уулзалт хийж, 1955 оны “Монгол-Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр”-ийг шинэчлэн байгуулах, Ханги-Мандал төмөр замын боомтыг байгуулах ажлыг эхлүүлэх асуудлыг хэлэлцсэн.

ЗТХЯ, “Монголын төмөр зам” ТӨХК болон концесс эзэмшигчийн төлөөллүүд 2023.01.12-ны өдөр ӨМӨЗО-ны Бугат хотын Ардын засгийн ордон, “Хөх хотын төмөр зам групп” компанийн төлөөлөлтэй уулзалт зохион байгуулж, Ханги-Мандал боомтоор дамжуулан БНХАУ-ын Бугат-Мандал чиглэлийн төмөр замын дэд бүтэцтэй холбох техникийн шийдлийг хэлэлцэн, санал солилцсон.

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2022 оны тушаалаар байгуулагдсан Техникийн комисс Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замын дээд, доод бүтцийн барилгын ажлын нийт гүйцэтгэлд хяналт шалгалт хийж, үүрэг даалгавар өгсөн ба үүрэг даалгаврын биелэлт 32 хувьтай байна.

Зүүнбаян-Ханги чиглэлийн төмөр замаар 2023 оны эхнээс зүгшрүүлэх тээвэрлэлт эхлүүлж, III улирлын байдлаар нийт 441,000 тн ачаа тээвэрлэсэн.

Төслийн барилгын ажлын нийт гүйцэтгэл 90.04 хувьтай байгаа бөгөөд 2023 оны III улирлын байдлаар дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

- Хоорондын замын дагуу километрийн шон, зуутын тэмдэгт байрлуулж дуусгау, 2 болон 3 дугаар зөрлөгт эрчим хүч татсан;
- Ханги өртөөний нарийн царигийн төмөр зам 34.5 км, өргөн царигийн төмөр зам 10.9 км барих ажлын гүйцэтгэл 86 хувьтай явагдаж байна;
- Нийт 226.9 км гол замд “УБТЗ” ХНН-ийн ВПР 02, “Монголын төмөр зам” ТӨХК-ийн ДС-32W машинаар өргөж чигжих, чиг залах ажлыг хийж, төслийн түвшинд хүргэн, 26000 м.куб балласт нэмсэн;



- Ханги, Номгон өртөөнд тус бүр 2 давхар 6 блок 720 хүний амрах байр, зоогийн газар, уурын зуух, цэвэршүүлэх байгууламжийн барилгын ажлын гүйцэтгэл 33 хувьтай байна;
- Дохиолол холбооны зураг төслийн ажлын гүйцэтгэл 90 хувьтай явагдаж байна;
- Ханги өртөө рүү 9 км цэвэр усны шугам татах ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

#### *6. Богдхан 144.8 км төмөр замын төсөл*

**Төсөл хэрэгжүүлэгч:** “Улаанбаатар төмөр зам” ХНН

**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** “Тавантолгой төмөр зам” ХХК

**Төслийн ТЭЗҮ зураг төслийн өртөг:** 15 сая ам.доллар

**Төслийн нийт өртөг:** 1.4 тэрбум ам.доллар

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2024 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 9.3.32, Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогын баримт бичгийн 3.3.1.2, “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.6.1.3, Засгийн газрын 2017 оны 142 дугаар тогтоолоор батлагдсан “Талын зам” үндэсний хөтөлбөрийн 3.1.4, Зам, тээврийн яам (хуучин нэрээр), ОХУ-ын “Оросын төмөр замууд” нээлттэй хувьцаат нийгэмлэг хооронд 2014 онд байгуулсан “Улаанбаатар төмөр замын шинэчлэл, хөгжлийн стратегийн түншлэлийн тухай хэлэлцээр”, Зам, тээврийн яам нь АХБ-тай “Холимог тээвэр болон логистикийн зангилаа зорилт”-ын хүрээнд Богдхан төмөр зам төслийг хэрэгжүүлэх Харилцан ойлголцлын санамж бичигт тус тус тусгагдсан.

#### **Төслийн ач холбогдол:**

- Улаанбаатар хотыг дундуур нь хоёр хувааж орших төмөр замын шугамаас шалтгаалан баригдсан хотын бүсэд байрлах төмөр зам, авто замтай нэг түвшинд огтлолцсон гармууд (төмөр замын одоогийн гол шугамын дагуу Мандал-Багахангай өртөөдийн хооронд нийт 10 гарам байна) дээрх хөдөлгөөний эрчим эрс багасна;
- Төмөр замаар тээвэрлэж байгаа хортой, тэсэрч дэлбэрэх, аюултай ачаанууд хотын төв бүсээс алсуур тээвэрлэгдэж, нийслэлийн хүн ам, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангана;
- Улаанбаатар хотын орчинд галт тэргэнд хүн дайрагдах, галт тэрэг, авто тээврийн хэрэгсэлтэй мөргөлдөх осол буурч, иргэдийн аюулгүй байдал дээшилнэ. Нийслэлийг дайран өнгөрч байгаа 35 км төмөр замыг хотын зорчигч тээврийн зориулалтаар ашиглан хөнгөн галт тэргэний үйлчилгээг хөгжүүлэх, нийтийн тээврийн хоёр дахь урсгалыг бий болгох боломж бүрдэнэ;
- Богдхан төмөр зам, Хөшигийн хөндий дэх логистикийн төвийн бүтээн байгуулалтыг дагаад тээвэрлэлтийн үйл ажиллагаатай холбоотой зарим аж ахуйн нэгжүүд хотын төв хэсгээс нүүж, хотын А бүсэд нийтийн хэрэгцээнд газар чөлөөлөгдөх боломж үүснэ.

**Төслийн ажлын явц:** ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын шинэчлэн баталсан 2022 оны 01 дугаартай ажлын даалгаврын хүрээнд төслийн техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ-ын 2022 оны Магадлалын ерөнхий дүгнэлтээр магадлуулан, ЗТХЯ-ны



Шинжлэх ухаан, технологийн Зөвлөлийн 2022.05.12-ны өдрийн шийдвэрээр батлуулсан.

Төслийн трассын дагуух газар чөлөөлөлтийн асуудлаар Нийслэлийн газрын харилцааны алба болон трасс дайран өнгөрч буй Сонгинохайрхан дүүрэг, Хан-Уул дүүрэг, Төв аймгийн газрын албатай хамтран Хан-Уул дүүрэгт 252, Сонгинохайрхан дүүрэгт 383 цахим өмчлөл бүхий нийт 635 нэгж талбараас одоогийн байдлаар 205 нэгж талбарыг шилжүүлсэн.

Төслийн эхний 37.5 км болох ПК105+000 - ПК142+500 хоорондох төмөр замын доод бүтцийн газар шорооны ажил 807,124.18 м.куб буюу 24.83 хувь, Технологийн замын газар шорооны ажил 92,716.51 м.куб буюу 100 хувьтай байна. Замын тэмдэг тэмдэглэгээний ажил болон барилга угсралтын ажилд ашиглах нийт 4 худаг гаргаж дууссан.

Засгийн газрын 2022.12.21-ний өдрийн хуралдааны тэмдэглэлд "Богдхан төмөр зам" төслийг "Улаанбаатар төмөр зам" ХНН-ээр хариуцуулан гүйцэтгүүлэх, тус төмөр замын шугамыг эцэслэн тохирох чиглэлээр Оросын талтай ажиллаж, холбогдох хууль тогтоомжийн хүрээнд арга хэмжээ авахыг холбогдох сайд нарт даалгасан. Үүний дагуу "УБТЗ" ХНН дээр ажлын хэсэг гарч, трассын судалгаа хийж байна.

Мөн Зам, тээврийн хөгжлийн сайдын 2023.05.08-ны өдрийн тушаалаар "Богдхан төмөр зам" төслийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

#### *7. Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 426 км төмөр замын төсөл*

**Төслийн захиалагч:** "Монголын төмөр зам" ТӨХК

**Төсөл хэрэгжүүлэгч:** Тодорхойгүй

**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** Урьдчилсан ТЭЗҮ-ийг Солонгосын төмөр замын корпораци (KORAIL), БНСУ-ын Тээврийн хүрээлэн (KOTI), Юушин Инженеринг Корпораци (Yooshin), Солонгосын Гео шинжлэх ухаан ба Эрдэс баялгийн нөөцийн хүрээлэн (KIGAM)-ийн хамтарсан консерциум гүйцэтгэж байна.

**Төслийн ТЭЗҮ зураг төслийн өртөг:** 11.3 тэрбум төгрөг

**Төслийн нийт өртөг:** 1.7 их наяд төгрөг ("Монголын төмөр зам" ТӨХК-ийн урьдчилсан тоцооллоор)

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2024 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай" Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолд нэгдүгээр үе шатанд барихаар тусгасан.

Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор "барих-ашиглах-шилжүүлэх" концессын эрхийг, Засгийн газрын 2012 оны 121 дүгээр тогтоолоор Төмөр замын суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус олгосон.

Засгийн газрын 2022 оны 105 дугаар тогтоолоор Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын төслийг "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулсан.



**Төслийн ач холбогдол:** Монгол Улсын нэгдсэн сүлжээнд Зүүн коридорын төмөр зам холбогдож, төмөр замын дотоодын тээврийн сүлжээ хөгжин, уул уурхайн бүтээгдэхүүнийг Сайншанд аж үйлдвэрийн парсад төвлөрүүлэх боломж бүрдэнэ.

Мөн төмөр замын бүтээн байгуулалтыг дагасан томоохон суурьшлын төвүүд бий болохоос гадна олон ажлын байр шинээр бий болно.

**Төслийн ажлын явц:** Засгийн газрын 2016 оны 146 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 431 км урт төмөр замын чигийг баталсан.

2011 онд Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн урьдчилсан судалгааг "МакКинсей энд компани" боловсруулсан. Төслийн талбайд хээрийн судалгааны ажлуудыг 2010-2013 онуудад хийж гүйцэтгэсэн.

2013 онд "Ниппон Козэй" компани төслийн техникийн зураг төслийг (FEED) боловсруулсан.

Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн төмөр замын техник эдийн засгийн урьдчилсан судалгааг Монгол Улсын Сангийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон БНСУ-ын Газар, дэд бүтэц, тээврийн яам хооронд байгуулсан санамж бичгийн хүрээнд "Монгол Улсын төмөр замын хөгжлийн стратеги Зүүн Азийн Төмөр замын нийгэмлэг (EARC)-ийн үүсгэн байгуулалттай уялдах нь" төслөөр хэрэгжүүлж, төслийн судалгааны ажлуудыг 2022 оноос эхлүүлэн үе шаттайгаар гүйцэтгэж байна.

2023.06.09-ний өдөр зохион байгуулагдсан Зам, тээврийн салбарын хөрөнгө оруулалтын чуулганд тус төслийг танилцуулж, хөрөнгө оруулагчдад сурталчилсан.

Засгийн газрын 2023 оны 300 дугаар тогтоолоор "Монголын төмөр зам" ТӨХК-ийн оролцоотой "Сайншанд-Баруун-Урт-Хөөт төмөр зам" ХХК байгуулах, тус компанид хөрөнгө оруулж хамтран ажиллах гадаад, дотоодын хуулийн этгээдийг сонгохыг ЗТХЯ, "Монголын төмөр зам" ТӨХК-д тус тус даалгасан.

Улмаар Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын тушаалаар концессын шууд гэрээ байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.

*8. Сүхбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замын төв коридорыг хос замтай болгох, шинэчлэл хийх төсөл*

**Төсөл хэрэгжүүлэгч:** "Улаанбаатар төмөр зам" ХНН

**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** "Улаанбаатар төмөр зам" ХНН

**Төслийн нийт өртөг:** 45.8 тэрбум төгрөг (2023 онд)

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2024 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 2 дахь заалт, "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны



хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний 3.6.1.2 дахь заалтад тус тус тусгагдсан.

**Төслийн ач холбогдол:** Төмөр замын төв коридорын ачаа нэвтрүүлэх хүчин чадал нэмэгдэх, эрсдэлийн түвшин буурах, дамжин өнгөрөх ачааны хэмжээ нэмэгдэх ач холбогдолтой.

**Төслийн ажлын явц:** ЗТХЯ-ны Шинжлэх ухаан, технологийн зөвлөлөөр Замын-Үүд Шаргын-Овоо 14.3 км хос замын ТЭЗҮ-ийг 2022.04.20-ны өдөр хэлэлцүүлж дэмжүүлсэн. Төслийн барилга угсралтын ажил 100 хувь дуусаж, тус чиглэлд тээвэрлэлт хийх боломж бүрдсэн.

2023 онд Сүхбаатар-Замын-Үүд чиглэлийн төмөр замд их засвар хийх хэсгийн гэмтлийн акт тогтоох, зураг төсөл боловсруулж, эрсдэлийн түвшинг тогтоон, 1 зэргээр бууруулах, 27 км-т их засварын ажлыг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Энэ хүрээнд зуны их засварын техникийн зөвлөгөөнийг зохион байгуулж, нийт 34 км замд их засвар хийх шийдвэрийг гаргуулан, зураг төсөл, төсвийг боловсруулсан.

2023.09.12-ны өдөр Ерөө-Орхон хоорондын замын 72 дугаар километрийн 9-р зуутаг төмөр бетон гүүр шинээр барьсантай холбогдуулан 1 км зам шилжүүлэн барих ажлыг гүйцэтгэсэн.

#### *9. Эрэнцав-Баянтүмэн чиглэлийн төмөр зам*

**Төсөл хэрэгжүүлэгч:** "Улаанбаатар төмөр зам" ХНН

**Төслийн ТЭЗҮ зураг төсөл:** "Улаанбаатар төмөр зам" ХНН

**Төслийн нийт өртөг:** Зураг төслөөр тодорхойлогдоно

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2023-2024 он

**Төслийн эрх зүйн үндэслэл:** "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтын 2 дахь заалтад тусгагдсан.

#### **Төслийн ач холбогдол:**

- ОХУ-тай төмөр замаар холбогдсон 2 дахь гарцын тээвэрлэлтийн хүчин чадал нэмэгдэж, Монгол Улсын зүүн бүсийн уул уурхайн бүтээгдэхүүн ОХУ-ын алс дорнодын боомтуудаар тээвэрлэгдэж, гуравдагч орны зах зээлд гарах боломж бүрдэнэ;
- Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн төмөр замтай холбогдож, Монгол Улсын төмөр замын зүүн коридор бий болно;
- Төмөр замын аюулгүй байдлыг хангаж, эрсдэлийн түвшнийг багасгана.

**Төслийн ажлын явц:** Зураг төслийн төвийн инженер техникийн ажилтнууд 2023.03.18-23-ны өдрүүдэд Эрэнцав өртөөнөөс Баянтүмэн өртөө хоорондын замд зам шинэчлэлтийн их засварын ажлын зураг төслийн хээрийн хэмжилтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Хэмжилтийн өгөгдлийн дагуу 238 км замын их засварын иж бүрэн зураг төсөл, төсвийг 100 хувь гүйцэтгэсэн.



Замын их засварын ажлыг гүйцэтгэх санхүүжилтийн эх үүсвэр одоогоор шийдвэрлэгдээгүй байна.

"УБТЗ" ХНН-ийн 2023 оны зам засварын төлөвлөгөөнд тусгасны дагуу 7 км замд өргөлтийн засварыг гүйцэтгэхээр ажиллаж байна. Замын дэр солих ажлыг бетонон дэрээр хэсэгчлэн солих ажил хийгдэж байна.

Түүнчлэн уг төслийн санхүүжилтийн асуудлыг "Богдхан төмөр зам" төслийн ажилтай хамтатган, Ажлын хэсгийн хүрээнд шийдвэрлэх саналыг Оросын талаас ирүүлсний дагуу холбогдох тооцоо судалгааг хийж байна.

#### **Авто замын төслүүд:**

*10. Өмнөговь аймгийн Тавантолгой-Манлай-Ханги чиглэлийн 477.1 км тусгай зориулалтын авто замын төсөл*

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2020-2023 он

**Төслийн ач холбогдол:** Тавантолгойн бүлэг орд газрын нүүрсийг экспортлох шинэ гарцыг нээх, борлуулалтын хэмжээг нэмэгдүүлэх, тухайн замын дагуу байрлах ашигт малтмалын орд газруудыг эдийн засгийн эргэлтэд оруулах, хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох, байгаль орчныг хамгаалах, бүс нутаг цаашлаад улс орны эдийн засгийн өсөлтийг бий болгох ач холбогдолтой.

**Төслийн ажлын явц:** Зам барилгын ажлыг 2023.03.15-ны өдөр эхлүүлсэн. Талбайд 1715 хүн хүч, 1016 машин, техник тоног төхөөрөмж байршин, хэмжилт, далангийн дүүргэлт, суурийн доод үе, цементээр бэхжүүлсэн суурь, хучилт, хиймэл байгууламж, чулуу бутлах ажил гүйцэтгэж байна. Барилгын ажлын гүйцэтгэл 77.2 хувьтай байна.

*11. Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын төсөл*

**Төсөл хэрэгжүүлэгч:** "МОНГОЛ ЛЗ ЗАМ ГҮҮР" ХХК

**Төслийн нийт өртөг:** 238.6 тэрбум төгрөг

**Төслийн хэрэгжүүлэх хугацаа:** 2021-2022 он

**Төслийн ач холбогдол:** Сэлэнгэ аймгийн Шаамар, Түшиг, Цагааннуур, Зүүнбүрэн сум болон Зэлтэр хилийн боомтыг хатуу хучилттай авто замаар холбох, улс орны хүнсний хангамжийг сайжруулах, зардлыг бууруулах, тээвэрлэлтийн зардлыг бууруулах, ард иргэдийг аюулгүй, тав тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх, аялал жуулчлалыг дэмжих зэрэг ач холбогдолтой.

**Төслийн ажлын явц:** Зам барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийг 2021.06.04-ний өдөр олгож, зам барилгын ажлыг эхлүүлсэн бөгөөд 2022 онд нийт ажлын 60 хувийг хийж гүйцэтгэсэн бол 2023 оны зам барилгын үндсэн ажлыг 4 дүгээр сарын 15-ны өдөр эхлүүлсэн.

Төслийн талбайд нийт 130 гаруй машин механизм, 300 гаруй хүн хүч байршин, хэмжилт, ухмал, далангийн дүүргэлт, суурийн доод үе, цементээр бэхжүүлсэн суурь, хучилт, гүүр, хиймэл байгууламжийн ажлыг гүйцэтгэж байна. Ажлын явц 87 хувьтай байна.



## *12. Улаанбаатар-Дархан чиглэлийн 204.1 км авто замын төсөл*

**Төслийн ажлын явц:** Багц 1, 3, 5 дугаар хэсгийн нийт 114 км авто замын хучилтын ажлыг 2020-2021 онд дуусгасан бөгөөд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг энэ оны 7 дугаар сард нээсэн. Нийт барилгын ажлын гүйцэтгэл 95-99 хувьтай байна.

Багц 2 буюу Хар модот давааны араас Урьхан хүртэлх 45.5 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Арж Капитал" ХХК шалгарч, 2021.09.03-ны өдөр гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн. Нийт барилгын ажлын гүйцэтгэл 79.72 хувьтай байна.

Багц 4 буюу Сүмбэрийн уулзвараас Цайдамын хөндий хүртэлх 45.08 км авто замын барилгын ажлын гүйцэтгэгчээр "Чайна Жео Инженеринг Корпораци" шалгарч 2021.09.27-ны өдөр гэрээ байгуулан барилгын ажлыг эхлүүлсэн. Нийт ажлын явц 73.78 хувьтай байна.

### **Иргэний нисэхийн төслүүд:**

*13. Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийг хэрэгжүүлэх ("Ховд", "Мөрөн", "Чойбалсан", "Дэглий цагаан", "Гурвансайхан")*

**Төслийн ажлын явц:** Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 253 дугаар тогтоолоор орон нутгийн зарим нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, ашиглалтыг сайжруулах төслийг "Төрийн өмчийн концессын зүйлийн жагсаалт"-д оруулж, хэрэгжилтийн хүрээнд Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын тушаалаар төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг зохион байгуулах ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Төслийн концесс олгох уралдаант шалгаруулалтыг 2023.09.22-ны өдөр зарласан бөгөөд 11 дүгээр сарын 22-ны өдөр нээхээр байна.

—oOo—